

ЭМГ-ЫН ДАРГА

БАТЛАВ

Д.СҮХЭЭ

**ДЭЛХИЙН ЭМЧ НАРЫН БАЯРЫГ ТОХИОЛДУУЛАН ЭМЧ НАРЫН ДУНД  
ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАРЫН УРАЛДААНЫ  
УДИРДАМЖ**

Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан эмнэлзүйн платформын хэрэглээг нэмэгдүүлэх хөгжөөнт тэмцээн болон эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна.

**НЭГ. “UP20DATE ПРОГРАММЫН ХЭРЭГЛЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ” ЭМЧ НАРЫН  
АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**Үндэслэл:**

Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд болон олон улсын мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага зэрэг олон улсын байгууллагын боловсруулсан бүхий л эмнэлзүйн удирдамжуудыг нэгтгэсэн “UpToDate” нэртэй цахим платформыг манай улсын бүх шатны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үнэгүй ашиглах боломжийг Эрүүл Мэндийн Яам бүрдүүлсэн.

UpToDate нь олон улсад хамгийн өргөн хэрэглэгддэг цахим платформын нэг бөгөөд 25 төрөлжсөн мэргэшлийн, 12.300 гаруй эмнэлзүйн сэдвийн өгүүллийг багтаасан, дэлхийн 191 орны 2 сая гаруй хэрэглэгчтэй болж өргөжсөн байна.

**Зорилго:**

Эмч нарын нотолгоонд суурилсан анагаах ухааны ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг чадварыг сайжруулах, эмнэлзүйн цахим платформ UpToDate-ийн хэрэглээг нэмэгдүүлэх.

**Хамрах хүрээ:**

Бүсийн оношилгоо эмчилгээний төв, эрүүл мэндийн анхан шатлалын байгууллагууд болох сум, өрхийн эрүүл мэндийн төв, Эрдэнэт Клиник, сувилал, Баян-Өндөр Мед нэгдсэн эмнэлэг, Эрдэнэт Медикал эмнэлэг, ХХЭМБ-уудын эмч нар

**Үйл ажиллагаа:**

1. Нэг баг нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Баг нь багийн ахлагчтай байх бөгөөд баг тус бүр өөрийн онцлог, уриаг агуулсан нэр, таних тэмдэгтэй, хувцсаар жигдэрсэн байна.
2. Тэмцээнийг 2023 оны 3-р сарын 24-ний 14:00 цагт Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын зааланд зохион байгуулж, шалгаруулна.

**Тэмцээний шалгуур үзүүлэлт, үнэлгээ:**

## ХОЁР. ЭМЧ НАРЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

### Зорилго:

Эмч нарын судалгаа шинжилгээний ажлыг нэмэгдүүлж, тэдгээрийн мэдлэг чадварыг хөгжүүлэх, шинэ бүтээл, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, тэдний бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх.

### Хамрах хүрээ:

Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, эрүүл мэндийн анхан шатлалын байгууллагууд, Эрдэнэт сувилал, клиник, Баян-Өндөр Мед нэгдсэн эмнэлэг, Эрдэнэт Медикал эмнэлэг, ХХЭМБ-уудын эмч нар.

Хугацаа: 3-р сарын 27-ний 14:00 цагт

Хаана: Эрүүл мэндийн Дэмжих төвийн А хурлын зааланд

### Үйл ажиллагаа:

№	Явагдах үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Удирдамжийг ЭМБ-уудад хүргүүлэх.	3-р сарын 14	ЭМГ-ын бичиг хэргийн ажилтан Г.Мөнх-Ундраа
2	Илтгэлийг хураангуй болон бүрэн эхээр авах.	3-р сарын 14-23	НЭМХ-ийн мэргэжилтэн Г.Будмаа
3	Нээлтийн арга хэмжээ.	3-р сарын 27-ний 14:00	АЗДТГ-ын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн О.Батцэнгэл
4	Шалгарсан илтгэлүүдийг хэлэлцүүлэх.	3-р сарын 27	ЭТҮХ-ийн мэргэжилтэн А.Хонгорзул
5	Хаалтын арга хэмжээ.	3-р сарын 27	Шүүгч нар

### Илтгэлд тавигдах нийтлэг шаардлага:

1. Илтгэлийг А4 хэмжээгээр хуудасны зүүн талаас 3.0 см, баруун талаас 1.5 см, дээр доороосоо 2 см, Arial фонтоор, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай 1.5, толгойн гарчиг Arial, Bold, үсгийн хэмжээ 14 байх бөгөөд үндэслэл, зорилго, зорилт, аргачлал, хамрах хүрээ, үр дүн, хэлцэмж, дүгнэлт, ашигласан номын жагсаалттай байхаар бэлтгэнэ.
2. Илтгэлийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй, хуудсын дугаарыг бичихгүй.
3. Илтгэл нь хүснэгт, зураг /график болон фото зургаар/ ном зүйг оролцуулан 3-5 нүүр байна.

4. Хүснэгт нь босоо шугамгүй, хуудас дамжаагүй, хүснэгтийн нэр товч, оновчтой байна. Хүснэгтийн гарчгийг хүснэгтийн дээд талд бичсэн байна.
5. Илтгэлийг сайтар нягталж шалгасан байх ба үг үсгийн алдаа, найруулга зүйг судлаач хянасан байна.
6. Хугацаа хоцроосон судалгааг хүлээж авахгүй.

#### **Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах журам:**

1. Судлаач нар эрдэм шинжилгээний хуралд оролцуулах судалгааны хураангуй болон бүтэн судалгааг 3-р сарын 23-ний дотор budmaaganbat@gmail.com хаягаар ирүүлсэн байна.
2. Судалгаагаа ирүүлсэн оролцогчдоос илтгэлд тавигдах шаардлага хангасан бүтээлүүдэд шүүлт хийж эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлэх судалгааны нэрсийг 3-р сарын 24-нд гаргана.
3. Эрдэм шинжилгээний бага хурал 3-р сарын 27-ний 14:00 цагт болж илтгэгчдийн илтгэлээ танилцуулах дараалал гарсан байна.
4. Нийгмийн эрүүл мэнд, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн 2 чиглэлээр шалгаруулна.
5. Шүүгчид 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.
6. Илтгэлийн PPT файлыг 8 минутад багтаан танилцуулна.

#### **Шалгаруулалт:**

1. Илтгэлийн үндэслэл, оновчтой байдал, судалгааны арга зүй, судалгааны ажлын гүйцэтгэл, практик ач холбогдол, илтгэх чадварыг харгалзан 0-5 оноогоор дүгнэнэ.
2. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:
  - 1 дүгээр байр 1 илтгэл
  - 2 дугаар байр 1 илтгэл
  - 3 дугаар байр 1 илтгэл

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр:

- 1 дүгээр байр 1 илтгэл
- 2 дугаар байр 1 илтгэл
- 3 дугаар байр 1 илтгэл

Нийт 6 илтгэл шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

#### **Удирдамж боловсруулсан:**

АШЭМБАНТҮХМ

*А.Хонгорзул*

А.Хонгорзул

#### **Хянасан:**

ЭТҮХ-ийн ахлах мэргэжилтэн

*П.Хишгээ*

П.Хишгээ

1. *Мэндчилгээ* - Багийн өөрсдийн багийг танилцуулсан 3 минутын танилцуулга хийнэ. Танилцуулгыг сонирхолтой, хөгжөөнтэй байдлаар шийдсэн байна. (1 оноо)
2. *Гэрийн даалгавар* - Багууд гэрийн даалгаварт 5 минутад багтаан эмнэлзүйн орчин үеийн шийдэл арга зүйг орон нутагт нэвтрүүлэх боломж сэдвээр илтгэл тавина. (5 оноо)
3. *Багийн ахлагчийн асуулт* – Багийн ахлагч урьдчилан бэлтгэгдсэн асуултаас сугалж хариулна. Бодох хугацаа – 1 минут. (5 оноо)
4. *Багийн гишүүдийн асуулт, хариулт* – Багийн гишүүд урьдчилан бэлтгэгдсэн асуултуудаас сугалж баг хоорондоо ярилцан нэг гишүүн нь асуултад хариулна. Бодох хугацаа – 8 минут. (5 оноо)

**Тэмцээний шалгаруулалт:**

1. Тусгайлан томилсон ажлын хэсэг тэмцээнийг дүгнэж шалгаруулна. Шүүгчдийн бүрэлдэхүүн 3 хүнээс бүрдэнэ.
2. Багийн гүйцэтгэх даалгавар, шалгуур үзүүлэлт тус бүрт шүүгчид оноог өгч хамгийн өндөр оноо авсан дарааллаар байр эзлүүлж шалгаруулна.
3. Тэмцээнийг удирдамжийн дагуу зохион байгуулж 1-3 байрыг шалгаруулна.

**Шагнал урамшуулал:**

Нэгдүгээр байр – 1, өргөмжлөл, мөнгөн шагнал

Хоёрдугаар байр – 1, өргөмжлөл, мөнгөн шагнал

Гуравдугаар байр – 1, өргөмжлөл, мөнгөн шагнал

Хөгжөөн дэмжигчдийн дундах тэмцээний ялагч – Дурсгалын зүйл, тэмдэглэлийн дэвтэр

### Тэмцээнд ирэх сэдвүүд:

1. Зүрх судасны эрхтэн тогтолцоо
  - a. Overview of hypertension in adults
  - b. Outpatient evaluation of the adult with chest pain
  - c. Heart failure: Clinical manifestations and diagnosis in adults
2. Амьсгалын замын эрхтэн тогтолцоо
  - a. Chronic obstructive pulmonary disease: Definition, clinical manifestations, diagnosis, and staging.
3. Бөөр, шээс дамжуулах эрхтэн тогтолцоо
  - a. Glomerular disease: Evaluation and differential diagnosis in adults.
4. Хоол боловсруулах эрхтэн тогтолцоо
  - a. Management of acute pancreatitis
  - b. Treatment of irritable bowel syndrome in adults
5. Халдварт өвчин судлал
  - a. Seasonal influenza in children: Clinical features and diagnosis.
  - b. Seasonal influenza in adults: Clinical manifestations and diagnosis.
6. Эх барих, эмэгтэйчүүд
  - a. Prenatal care: Patient education, health promotion, and safety of commonly used drugs.
  - b. Obesity in pregnancy: Complications and maternal management.
7. Үе судлал
  - a. Diagnosis and differential diagnosis of rheumatoid arthritis.
8. Хүүхдийн өвчин судлал
  - a. Community-acquired pneumonia in children: Outpatient treatment.
9. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ
  - a. Approach to the adult patient with syncope in the emergency department.